



СҮРЬЕЭ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч сүрьеэгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг санаачилгатай гүйцэтгэдэг, хамт ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн хүндэтгэлийг хүлээсэн байх (хамт олны хурлын тэмдэглэл),
2. Мэргэшлээрээ ажилласан 8 жилд хийсэн ажлын тайланг товч тоон үзүүлэлтээр гаргах,
3. Сүрьеэгийн мэргэжлийн тусламж үйлчилгээнд зайлшгүй гардан хийх үйлдлийг гүйцэтгэсэн талаар тайлан гаргасан байх, шинэ туршлага нэвтрүүлсэн байх,
4. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, онол практикийн хуралд илтгэл хэлэлцүүлсэн, мэргэжлийн сэтгүүлд хураангуйлан болон өгүүлэл 1-2 удаа хамтран бичиж хэвлүүлсэн байх (баримтуудыг хавсаргах),
5. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллаж дотоод гадаадад мэргэжлийн сургалтад хамрагдсан, сүүлийн 5 жилд тус бүр 3 багц цагийн сургалтад хамрагдсан байх (гэрчилгээ болон сургалтад хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил жилээр нь багцлан хавсаргах),
6. Нийгэмлэгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол идэвх санаачилгатай оролцдог байх,
7. Мэргэжлийн зэрэг горилогчийн өргөдлийн маягтаас гадна хавсаргасан Хавсралт 1-ийг бөглөн байгууллагын удирдлага хамт олны хурлаар хэлэлцүүлэн, дэмжлэг авч, зөвшөөрч, тодорхойлсон байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч сүрьеэгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг санаачилгатай гүйцэтгэж ирсэн, хамт ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн хүндэтгэлийг хүлээсэн (хамт олны хурлын тэмдэглэл),
2. Мэргэшлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайланг товч тоон үзүүлэлтээр гаргах,
3. Сүрьеэгийн мэргэжлийн тусламж үйлчилгээнд зайлшгүй гардан хийх үйлдлийг өөрөө гүйцэтгэхийн зэрэгцээ залуу эмч нарт зааж сургасан байх, шинэ туршлага нэвтрүүлсэн байх,
4. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, онол практикийн хуралд илтгэл хэлэлцүүлсэн, мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл бичиж (3-аас доошгүй) хэвлүүлсэн, өөрийн нэрээр гаргасан бүтээлийн жагсаалт байх, (баримтуудыг хавсаргах)
5. Сүрьеэгийн чиглэлээр 2-оос доошгүй мэргэжилтнийг дагалдуулан сургасан байх (холбогдох баримт, тушаалыг хавсаргах),

6. Сүүлийн 5 жилд тус бүр 3 багц цагийн сургалтад хамрагдсан байх (гэрчилгээ болон сургалтад хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил жилээр нь багцлан хавсаргах)
7. Нийгэмлэгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол идэвх санаачилгатай оролцдог байх,
8. Мэргэжлийн зэрэг горилогчийн өргөдлийн маягтаас гадна хавсаргасан Хавсралт 1-ийг бөглөн байгууллагын удирдлага хамт олны хурлаар хэлэлцүүлэн, дэмжлэг авч, зөвшөөрч, тодорхойлсон байх.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч сүрьеэгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна.

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг санаачилгатай гүйцэтгэж ирсэн, салбартаа нэр хүндтэй, хамт ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн хүндэтгэлийг хүлээсэн (хамт олны хурлын тэмдэглэл),
2. Мэргэжлээрээ ажилласан сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайланг товч тоон үзүүлэлтээр гаргах,
3. Сүрьеэгийн мэргэжлийн тусламж үйлчилгээнд зайлшгүй гардан хийх үйлдлийг өөрөө гүйцэтгэхийн зэрэгцээ залуу эмч нарт зааж сургасан байх, шинэ туршлага нэвтрүүлсэн байх,
4. Мэргэжлийн түвшинд зөвлөх, бие даан мэргэжлийн санал дүгнэлт гаргаж ирсэн үнэлгээнд багийн ахлагч эсвэл гишүүнээр ажилласан бодлогын бичиг баримт боловсруулахад биечлэн оролцсон байх /холбогдох баримт, тушаал хавсаргах/
5. Өөрийн нэрээр болон хамтран гаргасан бүтээлийн жагсаалттай байх, тухайн бүтээлүүд нь мэргэжлийн сэтгүүлд (5-аас дээш) хэвлэгдсэн байх, /баримтуудыг эх хувиар хавсаргах/,
6. Тухайн мэргэжлийн чиглэлээр эмч мэргэжилтнүүдийг дагалдуулан сургаж, мэргэжлийг дээшлүүлсэн байна /холбогдох баримт, тушаалыг хавсаргах/
7. Нийгэмлэгээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд бүтээлчээр тогтмол идэвх санаачилгатай оролцдог байх,
8. Өөрийн ажилласан хугацааны ажлын тайлан туршлагыг нэгтгэж байгууллагын удирдлага, хамт олноор баталгаажуулсан байх.